

АНХАН ШАТНЫ СУРАГЦАГЧДАД ХАНЗ ҮСГИЙГ ЗААХ АРГАЧЛАЛ

Б.Ганчулуун, доктор, Б.Цэцэгбадам, магистр, НХУС

Abstract: The teaching purpose of Chinese character class is to master the form, pronunciation, meaning and structure of Chinese characters in accordance with the system. And let the learners to grasp a look on the understanding of Chinese characters and the ability to write Chinese characters in the correct order. In some countries, there are no Chinese characters in the mother tongue. So the country in the primary stage of teaching Chinese characters in the course of the study found that the beginning of the students are not interested in learning Chinese characters. If the student correctly grasps the structure, the rule and the basic theory of Chinese characters, then it can understand and recite the Chinese characters on the basis of the meaning and pronunciation of Chinese characters.

We then through this thesis investigation of Chinese teacher, Chinese scholar, researcher put forward methods on how to recite Chinese characters, hieroglyph analysis, and effectively improve the teaching effect of Chinese characters. This paper consists of three parts, the first is the theoretical basis, the second is the research and experimental conditions, and the third is the conclusion part. In addition to the reference section.

In the theoretical part, the theoretical background, the historical evolution of Chinese and Chinese characters, the teaching of Chinese characters, etc.. he research and experiment part includes the content of the Chinese character teaching methods proposed by the researchers and scholars, and determine which method is suitable for the learners, how to recite the Chinese characters and so on.

Түлхүүр үг: ханз үсэг, онцлог, зүй тогтол, заах аргачлал

Онолын хэсэг

Авианы бичигтэй орны суралцагч утга бичиг болох ханз үсгийг хүлээж авч ойлгох нь нэлээд хэцүү байдаг. Анх ханзыг хараад зураг зурахтай адил төсөөлөн үздэг бол заримд нь адармаатай замбараагүй зураас, тэмдэгт шиг харагдаж хаанаас нь эхэлж бичихээ мэддэггүй. Иймээс багш ханзны үүсэл, хувирлын зүй тогтлыг зааж өгч эхнээс нь цэгцтэй эзэмшихэд тусалж ханзны талаарх суурь ойлголтыг төрүүлж, ханзыг таних логик эхлэлийг тавьж эзэмших гэж буй хэлнийх нь бичиг үсгийн талаарх ухагдахууныг бий болгох ёстой.

Ханз үсэг нь хятад хэлний гол үндэс, амин сүнс бөгөөд хятадын ард түмний түүх соёлыг таньж мэдэх, түгээн дамжуулах чухал хэрэгсэл юм. Иймээс эрдэмтэн судлаачид хятад хэл сурч буй гадаад оюутнууд ханз үсэг сурахдаа бэрхшээж халширдаг хандлагыг хэрхэн бууруулах, ханз үсгийг заах болон сурах оновчтой, үр дүнтэй арга замыг эрэлхийлж, сургалтын явцад тохиолддог бэрхшээлийг багасгах зорилгоор сургалт, судалгаан дээр тулгуурлан зарим саналыг дэвшүүлж байна.

Судлаачид анхан шатанд ханз үсгийн сургалтын үр дүнг дээшлүүлэхэд онцгой анхаарч, хятад хэлний сургалтан дахь ханзны сургалтын

өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, гадаад дахь хятад хэлний сургалтанд түгээмэл хэрэглэж байгаа сургалтын аргууд нь ихэнх нь “хэл бичгийн” буюу унших бичихийг голлосон байдаг нь анхлан суралцагчдад тийм ч үр дүнтэй биш байна гэж үзжээ.

«... Анхан шатны сургалтанд дан бичүүлэх, уншуулах аргууд нь суралцагчдад ханз сурах нь маш хэцүү гэсэн сэтгэгдлийг төрүүлдэг. Энэ нь ханзны сургалтын үр дүн хангалтгүй байхад хүргэж байгаа бөгөөд асуудлын гол нь ханз үсгийн мөн чанар, бүтцийн онцлог, зүй тогтлыг орхигдуулж, суралцагчдын танин мэдэхүйн ачааллыг хэтрүүлж байгаад оршиж байна.»¹

Анхан шатанд юуны өмнө ханзны бие даасан хичээл орох нь чухал бөгөөд ханз үсгийн авиа, хэлбэр, утгын нэгдмэл онцлог болон хоорондын харилцан уялдаа хамаарал, хэлбэр утгыг анхаарах; ханзны гол зүй тогтол болох “дүрс, тэмдэгтээр дамжуулан эхлээд бие даасан дан бүтэцтэй ханзыг дараа нь нийлмэл бүтэцтэй ханз заах; зургаар дамжуулан ханзны гарал үүсэл, учир зүйг ойлгуулан тайлбарлах нь ханзыг сонирхолтой

1 [2:13] Ph.D Yin Jinghua AHV Вермонтийн их сургууль

болгож тогтоож нүдлэхэд илүү үр дүнтэй болно. Мөн ханз үсгийг үгтэй нь нягт уялдаатай заах нь зүйтэй. Үсэг нь хятад хэлний бүтцийн онцлогт чухал байр суурь эзэлдэг нэгж бөгөөд үг хэллэг, дүрмийн сургалтын үндсэн нэгж болдог. Иймд хэлбэр, авиа, утгын нэгдэл болох ханз үсгийг зөвхөн бичгийн хэлний нэгж гэж үзэж болохгүй бөгөөд ханзыг тодорхой хэлэхүйн орчинд текст, өгүүлбэр, үгэнд хэрэглэгдэж байгаа байдлаар нь заах нь ханзны утга, хэрэглэх аргыг эзэмшихэд их чухал.

Дээр дурьдсаны дагуу эхлээд өргөн хэрэглээний бие даасан ханзнуудыг заана. Үүнд: зурлага, зурлагын дэс дараалал болон хажуугийн зурлага буюу түлхүүр ханзыг сайтар эзмшүүлэхэд онцгой анхаарна. Учир нь анхан шатанд хятад хэлний гол утга учир болох ханзыг системтэй эзмшүүлж сайн суурийг тавих нь дунд болон дээд шатанд хятад хэлээ сайн эзэмших суурь нь болдог.

Ингээд бид ханзны хичээл дээр хэрэглэдэг зарим нэг сонирхолтой дасгалуудыг судлан туршилт хийлээ. Үүнд:

1. Ханз хайчлах: Нэг ханз үсгийг томоор бичээд зурлага зурлагаар нь салгаж хайчлаад тарааж өгнө. Суралцагчид бичилгийн зөв дарааллаар нь нийлүүлж тухайн ханзыг бүтээж хоосон нүдэнд наана.
2. Түлхүүр үсэг: Ханз үсгийг бүрдүүлбэр хэсгээр нь хувааж салгаад оюутнуудад өгч эдгээр хэсгүүдийг ашиглан дахин шинэ үсэг бүтээлгэнэ.
3. Ханзыг задалж бичих: Ханз үсгийн картыг оюутнуудад тараан өгөн ханзыг бүрдүүлбэр хэсэг буюу зурлагаар нь салгаж самбарт бичнэ.
4. Ханз үсэг олох: Нэг бүлэг ханз дотроос төсөөтэй зурлагатай буюу түлхүүр үсэгтэй ханзнуудыг ялгаж олно.
5. Өнгөөр ялган будах: Багшийн заасны дагуу тухайн ханзны аль нэг зурлага буюу бүрдүүлбэр хэсгийг өнгөөр ялгаж будна.
6. Ханз наах: Багш эхлээд ханзны картыг оюутнуудад тарааж өгнө. Дараа нь самбарт галиг, орчуулгыг бичнэ. Оюутнууд авсан картаа тохирох байрыг нь олж наана.
7. Дутуу зурлагыг нөхөх: Багш ханз бүрт нэгээс хоёр зурлагыг нь дутуу үлдээж оюутнуудаар гүйцээн нөхүүлж бичүүлнэ.
8. Алдаатай ханзыг олох: Багш зарим ханзыг зориуд буруу бичиж оюутнуудаар алдааг олуулна.
9. Үсэгт оньсого таах: Тухайн ханз үсэгтэй холбоотой оньсогыг оюутнуудаар таалгана.

Оюутнуудын ханз эзэмших явцад гаргадаг түгээмэл алдаа:

- Ханз үсгийг эзмшүүлэх явцад оюутнууд дараах алдааг их гаргадаг. Үүнд:
- Ханзны бүтцийг ойлгоогүйгээс ханзны харьцааг алдагдуулах, том жижиг бичих
- Зүүнээс баруун, дээрээс доош, дотроос гадагш гэсэн зарчмыг алдагдуулж зурлагын эхлэлийг хаанаас ч хамаагүй бичих
- Нэг ханзыг хоёр ханз мэт ойлгож түлхүүр үсэг, хажуугийн зурлагыг хэт зайтай бичих
- Ижил төстэй ханзыг андуурч бичих
- Хоёр үетэй ханзыг нэг үетэй нэг ханз мэт бичих зэрэг алдаануудыг гаргадаг.

Бид дээрх алдааг багасгах, ханз тогтоох аргыг эзмшүүлэх зорилгоор өргөн хэрэглээний хамгийн түгээмэл тодорхой тооны ханзыг тогтооход мөн харьцангуй олон зурлагатай ханзыг хэрхэн тогтоож байгааг туршин үзэж дүн шинжилгээ хийлээ.

Туршилт

ГХС-ийн ХХБ-2 ангийн 9 оюутанг 2 баг болгон хуваан өмнө нь сурч байгаагүй 炒、辣、蒸、饼、酱、煮、肠、蔬、捐、贫、痛、赢、输、鼻、破 гэсэн нийт 15 ханзыг, ХХБ-1 ангийн 19 оюутанг 2 баг болгон 是、吗、老、国、同、妹、看、家、习、奶、吃、床、堂、视、食、觉、澡、睡 өргөн хэрэглээний 20 ханзыг хэрхэн тогтоон цээжлэж байгааг ажиглан туршилт хийв.

1. **Ханз хайчлах:** 15 ханзаа урьдчилан хайчилж бэлдээд зурлагаар нь салган багуудад өгч шинэ ханз бүтээлгэхэд оюутнууд өмнө нь сурсан ханзаа эвлүүлэн олж байсан. Хэсэг хугацааны дараа нь 15 ханзыг картаар үзүүлээд дараа нь тухайн ханзыг бүтээлгэхэд оюутнууд хурдан хугацаанд тэрхүү ханзыг эвлүүлж байсан. Ялангуяа ХХБ-2 ангийн оюутнууд ХХБ-1 ангитай харьцуулахад тэрхүү ханзыг богинохон хугацаанд бүтээн олж байсан юм.
2. **Түлхүүр үсэг ба ханзыг задалж бичих:** Энэхүү 2 аргыг хамтад нь ашигласан болно. Нийт 15 шинэ ханзаа хажуугийн зурлага буюу түлхүүр үсгээр нь салган багуудад хуваан өгч эвлүүлж олсон ханзаа хэрхэн хурдан хугацаанд нүдэлж тогтоож байгааг шалган оюутан бүрийг самбарт гарган бичүүлэхэд ХХБ-2 ангийн оюутнууд 辣、蒸、饼、酱、蔬、赢、输、鼻

гэсэн ханзны аль нэгэн зурлагыг дутуу орхих эсвэл түлхүүр үсгэн ард өөр үзсэн ханзаа бичиж байсан хэдий ч 2-р ангийн оюутнууд хятад хэлний түлхүүр үсэг буюу хажуугийн зурлагыг сайн эзэмшсэн байсан нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. ХХБ-1 ангийн оюутнууд ханзны зурлагаа буруу бичих болон зурлагын дэс дарааллаар бичихгүй хялбарчлах тохиолдол гарсан.


3. **Ханз үсэг олох, ханз наах:** Энэ 2 аргыг өгүүлбэр дундаас сая сурсан шинэ 15 ханзаа олж сонсоод цаасан дээр бичиж буулгах байдлаар туршиж үзлээ. Үүний өмнө ханз тус бүрийхээ утга болоод галиг, хөгийг оюутнуудад хэлж өгөн дараагаар нь өгүүлбэр хэлж бичүүлэхэд ХХБ-2 ангийн нэг баг 肠、蔬、蒸、贫、捐、 гэсэн ханзыг сайн тогтоож аваагүй нь ажиглагдлаа. Харин нөгөө баг нь 蔬、辣、赢、输、酱

гэсэн ханзыг хараахан тогтоож аваагүй байсан юм. Гэхдээ галиг болон орчуулгыг бичсэн байсан нь туршилтаас үзэхэд олон зурлагатай болон бичихэд төвөгтэй ханзыг хараахан бичиж чадахгүй байв.

4. **Дутуу үсгийг нөхөх, алдаатай ханзыг олох:** Багш самбарт сая сурсан 15 ханз бүрийн аль нэгэн зурлагыг зориуд дутуу мөн буруу бичээд баг бүрээс тус бүр нэг оюутан ээлжлэн гарах маягаар алдаатай болон дутуу зурлагатай ханзыг засаж бичүүлэхэд 鼻、赢、破、酱 гэх 4 ханзны зурлагын дутуу ба буруу бичиж алдааг нь олж чадахгүй байсан. Үүнээс үзэхэд дээрх 4 ханзны эхний 2 ханзны зурлага ихтэй, цээжлэн тогтооход төвөгтэй бусад ханзтай андуурахад хүргэдэг гэсэн дүгнэлтэнд хүрч байгаа юм.

Диаграмм 1

ХХБ-2 ангийн ханз тогтоосон байдлыг графикаар харуулбал:




Судалгааны үр дүнг дээрх графикт үзүүлэлтээр нь задлан ангилахад өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэгддэг, цээжлэн тогтооход хялбар, ханзны зурлага цөөн, мөн түлхүүр үсэг буюу хажуугийн зурлагын тусламжтайгаар тухайн ханз үсгийг цээжлэн тогтоосон байна. Үүнээс ХХБ-2 ангийн 9 оюутнаас 煮、痛 гэсэн 2 ханзыг бүгд 100% бичсэн байв. Үүний дараа 肠 гэсэн ханзыг 89%, 饼 гэсэн

ханзыг 78%, 破 гэсэн ханзыг 67%, 捐 гэсэн ханзыг 56%, 炒 гэсэн ханзыг 33%, 辣 гэсэн ханзыг 22%, 酱 гэсэн ханзыг 11% -ийн үзүүлэлттэй тус тус бичиж буулгасан байна. Үлдсэн 输、贫、赢、蔬、鼻 гэсэн 5-н ханзны аль нэгэн зурлагыг дутуу бичих, хажуугийн зурлага буюу түлхүүр үсгийг орхин бичих зэрэг байдлаар бичих гэж оролдсон байлаа.

Диаграмм 2

ХХБ-1 ангийн ханз тогтоосон байдлыг графикаар харуулбал:



ХХБ-1 ангид явуулсан судалгаанаас харахад өдөр тутам болон мэргэжлийн хичээл дээр тогтмол давтагдан хэрэглэгддэг 是、吗、老、国、同、妹、看、家 гэсэн ханзыг цээжлэн тогтоосон байна. 50%-иас доош үзүүлэлттэй 习、奶、吃、床、堂、视、食、觉、澡、睡 ханзны утгыг мэддэг боловч аль нэгэн зурлагыг дутуу орхин бичих, хооронд нь хольж солих гэх зэрэг байдлаар бичиж буулгахыг оролдсон байлаа.

Туршилтаас ажиглахад ханзны хичээл дээр эдгээр аргачлалыг хэрэглэхэд ханз сурах сэдэл тэмүүллийг нэмэгдүүлж хичээлийг сонирхолтой болгож бүгд идэвхитэй оролцож байв. Гэхдээ энэ бүх аргуудаас ханз наах, ханз хайчлан эвлүүлэх, дутуу зурлагыг нь нөхөх арга илүү үр дүнтэй байсан гэж хэлж байлаа. Судалгаанд оролцсон оюутнуудаас хэрхэн ханзаа цээжилж, тогтоодог талаар асууж ярилцахад дараах аргыг хэлж байсан юм. Үүнд:

1. Ханзыг олон удаа хуулж бичих
2. Тухайн ханзыг ашиглан өгүүлбэр зохиох
3. Ханзны түлхүүр үсэг юмуу хажуугийн зурлагын тусламжтайгаар
4. Эх бичвэр дотор олон дахин давтагдан гарах явцад
5. Харж тогтоох

Дээрх оюутнуудын хэрэглэдэг аргад задлан шинжилгээ хийвэл хятад хэлний ханзны анхан шатны мэдлэггүй оюутнуудад тухайн хичээлийн багш нь ханзыг бичих даалгавар, өгүүлбэр зохиох даалгавар түлхүү өгдөгтэй холбоотой байдаг байна.

Эдгээр аргачлалыг бага насныханд мөн насанд хүрсэн хүмүүст ч ашиглаж болно.

ДҮГНЭЛТ

Орчин цагийн хятад хэлний 《中华字海》 хэмээх толь бичигт нийт 87019 ширхэг ханз оруулсан байдаг ба үүнээс өргөн хэрэглээний 3500 ширхэг ханз байдаг байна. Хэдийгээр дүрс үсэггүй орны суралцагчдын хувьд өргөн хэрэглээний 3500 ханз цээжилж тогтооно гэдэг бэрхшээлтэй боловч үндсэн 6 зурлага, тэдгээрээс бүтсэн туслах зурлага өөр хоорондоо нийлж ханзыг бүтээж байдаг тул анхан шатны сургалтаар оюутнуудад ханзны гарал үүсэл, галиг, дуудлага, утгыг сайтар эзэмшүүлэх нь зүйтэй.

Дээрх судалгаанаас үзэхэд бүх аргыг нэг хичээлийн цаг дээр хэрэглэх нь учир дутагдалтай. Тухайлбал, ханзыг зурлагаар хайчлах дасгалыг багш хичээлийн өмнө бэлтгээд зурлагаа хичээлийн цаг дээр оюутнуудад тараан өгч ханзаа эвлүүлэх нь илүү тохиромжтой. Харин хичээлийн цаг дээр оюутнуудаар хайчлуулан эвлүүлэх нь үр өгөөжтэй боловч хугацааны хувьд сунжирч гол зорилгоосоо хөндийрч болзошгүй.

Судалгаанд оролцогч оюутнуудын хувьд ханз наах дасгал илүү үр дүнтэй гэж онцолж байв. Иймд тухайн багш өөрийн заах арга, туршлагыг дээрх аргын аль нэгтэй хослуулан хэрэглэх нь хичээлийг улам сонирхолтой болгохын сацуу оюутнуудын сурах сэдлийг нэмэгдүүлэх боломжтой.

Түүнчлэн судалгаанаас ажиглахад ханз үсгийн утга нь үгэнд хэрэглэгдэн орж байж сая илүү ойлгомжтой тодорхой болдог бөгөөд үг, өгүүлбэрээс салангид дан ханзыг сурч эзэмшихэд хэцүү, бас сонирхолгүй байдаг байна. Үсэг, үг хоёрыг нягт уялдаатай зааснаар суралцагсад үсгийг хараад утгыг тааварлах чадвартай болно.

Таньж тогтоох явцад суралцагчдаас зүгээр хоосон механикаар цээжлэхийг шаардах бус аль

болох ханзны утга, дуудлагыг нь ашиглан ханзыг ойлгож тогтоолгохыг анхаарах хэрэгтэй.

Мөн практик сургалтад интернэт дэх ханзны сургалтын нөөц хэрэглэгдэхүүнийг оновчтой ашиглах нь хичээлийг илүү бодитой үр өгөөжтэй сонирхолтой болгож сургалтын чанарыг дээшлүүлэх ач холбогдолтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Лиү шүнь. (2008). *Introduction to learn foreign language education*. Бээжингийн Хэл Соёлын Их Сургуулийн хэвлэлийн газар

Ван вэй, Сунь чи. (2012). “Хятад хэлний багшийн танхимийн сургалтын гарын авлага”. Дээд Боловсрол хэвлэлийн газар

Жан ши тао. (2007). *Анхан шатны хятад хэлний уншлага*. Бээжингийн Их Сургуулийн хэвлэх газар

Жан пин пин. (2001). *Түгээмэл хэрэглэгддэг ханзны түлхүүр үсэг*. Хятад хэлний Боловсрол хэвлэлийн газар

"Гадаад хэл заах аргазүйн онол
практикийн тулгамдсан асуудал" эмхэтгэл.
2013